

БАРИМТАТ НЭВТРҮҮЛЭГ БҮТЭЭХ СҮҮЛИЙН ҮЕИЙН
ЗАРИМ ХЭВ ЗАГВАР

Т.Өнөрсайхан*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)

Түлхүүр үгс: баримтат нэвтрүүлэг, баримтат кино, ажиглалтын хэв загвар, тайлбарласан хэв загвар, гүйцэтгэлийн хэв загвар, оролцооны хэв загвар, интерактив хэв загвар

Телевизийн бүтээлийг үзэгчид “үзэж байна”, “үзэхгүй байна” гэсэн үндсэн хоёр шалгуураар л тодорхойлдог. Эхэндээ харахад үзэгч сонголт хийж байгаа мэт боловч үнэндээ тэд телевиз асаагаад яг тийм төрөл зүйл, форматын нэвтрүүлэг үзнэ гэсэн зорилго тавьдаггүй. Тухайн цаг мөчид анхаарал татсан, сонирхолтой бүтээлийг л сонгодог байна. “Үзэгчид зурагтын өмнө суухдаа юу хүсэж байгаагаа мэддэггүй, суваг сольж тухайн үед анхаарал татсан нэвтрүүлгүүдийг сонгон үздэг. Тиймээс тэдний хүслийг урьдчилан таамаглаж, сонирхлыг нь татах бүтээл хийх ёстой. Үүний тулд зорилтот бүлгээ судлах, тэдний онцлогийг ойлгож, мэдэх шаардлагатай.” гэж Америкийн судлаач Ийстман С.Т, Фергусон Д.А нар “Мэдээллийн хэрэгслийн хөтөлбөр төлөвлөлт: стратеги ба арга зүй” номондоо дурджээ. (Eastman S.T &

Ferguson D.A, 2012) Тэгэхээр үзэгч үзэж байна эсвэл үзэхгүй байна гэсэн товч шалгуур бол үнэндээ үзэгчээс шалтгаалдаггүй байх нь. Шалгуурыг үзэгч тавьж байгаа мэт боловч дам утгаараа тухайн нэвтрүүлгийн уран бүтээлийн багаас хамаарна.

Телевизийн бүтээл хэзээд багийн хамтын хөдөлмөр байдаг. Бие биенээ үл давтах чадвар, туршлагатай уран бүтээлчид нэг зорилгын дор тус тусын үүргийг гүйцэтгэж энэ багийг бүрдүүлнэ. Тэднийг нэвтрүүлгээ үзэгчдийг “үзтэл” хийхэд хүлээн авагчийн судалгаа, бүтээлийн төрөл зүйл, формат, агуулга сэдэв, уран бүтээлийн багийн ур чадвар туршлага, хөрөнгө оруулалт, техник технологи гэсэн олон талын хүчин зүйл нөлөөлдөг юм.

Зохиогч тус өгүүлэлдээ эдгээр хүчин зүйлийн гол цөм болсон бүтээлийн хийц, хэв загварын сүүлийн үеийн чиг хандлагын талаар баримтат нэвтрүүлгийн онцлогт тулгуурлан бичсэн болно. Ингэхдээ судалгааны түүхчилсэн, харьцуулсан, задлан шинжилсэн аргуудыг ашиглалаа.

1960-аад оны үед телевизийн салбарт олноор хийгдэж байсан

баримтат нэвтрүүлэг 1980-аад он гэхэд энтертейнмент төрлийн бүтээлүүдэд “түрэгдэх” байдал анзаарагдаж эхэлсэн байдаг. Гэхдээ сүүлийн үед нийгмийн сүлжээ хүчээ авахын хэрээр энэ байдал өөрчлөгдөж, баримтат нэвтрүүлгийн үнэ цэн өссөөр байна. Мэдээллийн хэт их урсгал дунд хүмүүс баталгаатай, бодит мэдээллийг нэг дороос ойлгомжтой байдлаар хүлээн авахыг хүсдэг болсон. Баримтат нэвтрүүлгүүд тэдний энэ хэрэгцээ шаардлагыг хангаж буй төрөл юм.

Телевизийн баримтат нэвтрүүлэг болон баримтат киног хольж хутгах, нэг ижил зүйл мэтээр тайлбарлах ташаа ойлголт мэр сэр байдаг. Үнэндээ “энэ хоёр бүтэц, хийцийн хувьд бие биеэсээ эрс ялгарна”. (Хулан, 2019)

Баримтат нэвтрүүлэг нь бие даасан төрөл болж нэгэнтээ хөгжсөн, бодит байдал, хүмүүсийг амьдралыг баримтжуулж хийдэг, сэтгүүл зүйн нэг чиглэлийн бүтээл юм. Тодорхой нэг сэдвийн талаар бодит мэдээлэл, үйл явдал, баримтыг үзэгчдэд хүргэхийг зорьдог. Өөрөөр хэлбэл, “мэдээлэл, үйл явдал эсвэл хүмүүсийн талаар үзүүлэхдээ бодит байдалд тулгуурлан ямар нэгэн уран зохиолын дүргүйгээр баримтжуулдаг нэвтрүүлгийн төрөл билээ” (СУИС, 2022)

Баримтат нэвтрүүлэг цэвэр сэтгүүл зүйн бүтээл болохын хувьд олон нийтийг бодит мэдээллээр хангах, танин мэдүүлэх, соён гэгээрүүлэх зэрэг үүргийн хүрээнд хийгдэнэ. Сэдвийн өргөн хүрээнд хийгддэг учраас нийгмийн эмзэг чухал асуудлыг хөндөх, түүнийг шийдвэрлэх, олон нийтэд нуугдмал далд мэдээллийг хүргэхэд тохиромжтой хэлбэр

юм. “Хачир чимэггүй” бодит байдлын илэрхийлэл гэж тодорхойлж болно. Нөгөө талаар телевизээр цацагдаж буй сэтгүүлчдийн бүтээл бүгд баримтат тулгуурласан байх ёстой. Тэгэхээр “бусад нь баримтгүй гэсэн үг үү?” гэсэн асуулт үүсдэг. Баримтат нэвтрүүлэгт хамаарах бүтээлүүд уран сайхны хэлбэрээс ангид үйл явдлыг хачир чимэггүйгээр, шинжлэлт бичлэгийн төрөл зүйлд тулгуурлан хийгддэг. Баримтат нэвтрүүлэг гэсэн ерөнхий ойлголтын хүрээнд юу үзүүлэх, яаж хэрхэн илэрхийлэх вэ гэдгээс хамаарч телевизийн нэвтрүүлгийн төрөл зүйлүүдээс сонгож ашиглана.

Баримтат нэвтрүүлэгт шинжлэх ухаан, танин мэдэхүйн цувралууд, эрэн сурвалжлах нэвтрүүлэг, реалити шоу (СУИС, 2022) докудрам, сурвалжилгууд зэрэг багтана. Эдгээрийг баримтат нэвтрүүлэг гэсэн ангилалд багтааж байгаа нийтлэг шинж нь баримт-бодит байдал нотолгоо юм.

Дээрх хэлбэрүүд бол телевизийн нэвтрүүлгийг хийц буюу формат, төрөл зүйлийн хувьд ангилж үзсэн байдал юм. Харин тэдгээрийг хийх хэв загварын тухайд АНУ, ОХУ, Японы судлаачид, найруулагчдын ангилсан түгээмэл загварууд байдаг. Өөрөөр хэлбэл, баримтат киноны *direct cinema*, *cinema verite* зэрэг хэв маяг байдаг шиг баримтат нэвтрүүлэгт ч мөн бүтээх загварууд бий. Гэхдээ энэ нь аль нэг төрөлд жишээлбэл, шинжлэх ухааны цувралд ажиглалт, эрэн сурвалжилгад оролцооны аргыг ашиглана гэсэн хатуу тогтсон хуваарь биш юм. Эрэн сурвалжилга, эсвэл танин мэдэхүйн цуврал, бүр цаашилбал реалити

шоуг ажиглалтын гэсэн нэг аргаар хийж болно. Гагцхүү хийх арга нь агуулгаа бүрэн илэрхийлж байх ёстой юм.

Баримтат нэвтрүүлэг бүтээх сүүлийн үеийн аргууд Америкийн баримтат бүтээл судлаачдын тодорхойлсон түгээмэл хэв загваруудад голчлон тулгуурлаж байна.

Эдгээрээс тайлбарласан баримтат нэвтрүүлгийн хэв загвар хамгийн түгээмэл арга юм. Бас уламжлалт ч гэж хэлж болно. Ерөнхийдөө энэ арга пост-социалист орнуудад илүүтэй хэрэглэгддэг. Үндсэн эх бичвэр, хөтлөгч, хөтлөгчийн хайрцагласан асуулт, илүү тодорхой гаргахыг хүссэн баримтаа хүчтэй дүрсэн өгүүлэмжээр илэрхийлэх зэрэг болно.

Роберт Флаэртигийн эскимосуудын тухай “Хойд нутгийн Нанук” анхны баримтат кино нь тайлбарласан хэв маягаар хийгдсэн байдаг. Тухайн үед энэ бүтээлийг баримтат кино гэж шууд нэрлээгүй ч телевиз, киноны салбарт “баримтат” гэсэн үг, санааг оруулж ирснээрээ түүхэн ач холбогдолтой бүтээл болсон билээ. Баримтат кино нь телевизийн нэвтрүүлэгт олон төрөл зүйл, хэлбэрийг бий болгосон гэж үздэг. “Хойд нутгийн Нанук” баримтат киног бүтээсэн энэ хэв загвар нь хожим баримтат нэвтрүүлэг төдийгүй телевизийн бүх төрлийн бүтээлд тусгалаа олжээ.

Тайлбарласан баримтат нэвтрүүлгийн онцлог нь ярилцлага, дүрсэн өгүүлэмжийг илүү тодотгож, баримтыг зохиогч өөрийн байр сууринаас задлан тайлбарлахад илүү дөхөмтэй, үзэгчдийг тодорхой нэг чиглэл рүү хөтлөн

аваачдаг. Ийм загвараар хийгдсэн нэвтрүүлгийн үзэгч зохиогчийн гол санааг тухайн цаг мөчид өөрийнхөөрөө задалж бодохоос илүүтэй нэвтрүүлгийн шугамд хөтлөгдөж үзсээр дуусдаг талтай. Нөгөөтэйгүүр, нэвтрүүлэгчийн уншсан эх бичвэр тухайн хөндөж буй асуудлаар үзэгчдэд системтэй, цэгцтэй мэдээлэл өгдөг. Монголын телевизүүдэд уламжлалт энэ загварыг хамгийн түгээмэл хэрэглэж байна.

Тайлбарласан хэв загварыг баримтат нэвтрүүлэгт төдийгүй баримтат кинонд ч идэвхтэй ашигладаг. Тухайлбал, эх орноосоо аргагүй эрхэнд дүрвэн Энэтхэг, Америкийг зорьсон монголчууд, Очирдара хувилгааны түүхийг өгүүлдэг “Дүрвэгсдийн жимээр” баримтат кино нь энэ загвараар хийгджээ. Мөн баримтат нэвтрүүлэг төдийгүй баримтат кинонд ч ашигладаг драмын аргыг Чанрав, Ханд нарын хооронд 1970 онд болсон яриаг сэргээн харуулах зорилгоор ашигласан байна. (Оюундарь, 2016)

Сүүлийн үеийн баримтат нэвтрүүлэгт ажиглалтын хэв загварыг түгээмэл ашиглах болсон. Энэ загвар нь реалити нэвтрүүлгийн үндсэн арга боловч үзэгчдэд нэвтрүүлгийн багийн зүгээс шууд үзэл бодлын шахалт үзүүлдэггүй, бодомж үлдээж, дүгнэлтийг өөрсдөө хийх боломж олгодог учраас бусад төрөл зүйлд ч ашиглаж байна. Ялангуяа эрэн сурвалжлах нэвтрүүлгүүдэд түгээмэл ашиглаж, хамгийн тохиромжтой хувилбараар тооцогдож байна. Европын эрэн сурвалжлах сэтгүүл зүйн гол төлөөлөгч Германы сэтгүүлч Гюнтер Вальрафын бүтээлүүд ихэнх нь энэ аргаар хийгдсэн байдаг.

“Хууртагдахгүйн тулд бусдыг хуурах” буюу зүсээ хувиргаж, дүрд орон эрэн сурвалжлах үйл ажиллагаа явуулдаг Гюнтер Вальраф Герман дахь арьс өнгөний үзлийн талаарх эрэн сурвалжлах нэвтрүүлгээ хийхдээ ажиглалтын хэв загварыг ашиглажээ. “Хар дээр цагаанаар” гэх энэ нэвтрүүлэгт тэрээр зүсээ хувиргаж Сомали улсаас ирсэн цагаач Квами Огонно болдог.

Ажиглалтын хэв загвар нь оролцогч төвтэй, урт хугацаанд хийгддэг онцлогтой. Гол зорилго нь аливаа зүйлсийн оршихуйн мөн чанар, бодит байдлыг харуулах юм. Бүтэн жилийн турш Гюнтер Вальраф Сомали улсаас ирсэн цагаачийн дүрд хувирч амьдрахдаа хүний жам ёсны эрхийг хэрхэн зөрчиж байгаа, цаасан дээр бичигдсэн

хууль бодит байдалд хэр зэрэг хэрэгжиж буйг ажиглалтын хэв маягаар харуулсан байдаг. Болж буй үйл явдлыг өөрийнхөөр нь орхиж, жам ёсны үйл явцыг харуулахыг зорьдог энэ загварыг шинжлэх ухаан, танин мэдэхүйн баримтат нэвтрүүлгүүдэд мөн түгээмэл ашиглаж байна.

“Хүннү пикчерс”-ийн бүтээл Өвөрхангай аймгийн малчин охин Гэрэлтжингийн тухай “Төлчин хүүхэд” баримтат нэвтрүүлэг нь ажиглалтын хэв загвараар хийгджээ. Баасан гарагийн хичээл дуусаж,

Орхон голыг гатлан хөдөө гэртээ ирэх охин мал төллөх хаврын цагаар ямар ажил хийдэг, малчин айлын ахуй амьдралыг ажиглаж бүтээсэн нэвтрүүлэг юм. (Ариунболд, 2024)

Ажиглалтын хэв загвараар хийсэн нэвтрүүлгүүд уран бүтээлийн багийн оролцоог хязгаарлаж, гол дүр, үйл явдлыг өөрийн жам ёс, тогтсон маягаар байх боломжийг олгодог

учраас энэ арга нь хамгийн идэвхтэйд тооцогддог. Ялангуяа төрөл бүрийн жагсаал цуглаан, нийгмийн хурцадмал асуудлын талаар нэвтрүүлгүүдийг сэтгүүл зүйн үүднээс тэнцвэртэй хүргэхэд хамгийн тохиромжтой загвар юм. Энэ төрлийн нэвтрүүлгүүдийн сул тал нь оролцогч төвтэй байдаг учраас судалгаа, цаг хугацаа нэлээн шаарддаг.

Баримтат нэвтрүүлгийн хамгийн идэвхтэй хийгдэж буй дараагийн хэв загвар бол оролцооны арга юм. Сэтгүүлч үйл явдлын оролцогч болно. Эхний тайлбарласан аргаас ялгарах онцлог нь урьдчилж бэлдсэн эсвэл дүрсэн өгүүлэмжид тааруулж бичсэн эх бичвэрийг ашиглах бус харин тухайн цаг мөчид болж буй үйл явдалд сэтгүүлч өөрийн байр сууриар шууд оролцдог ороо онцлогтой. Жишээлбэл, отрын гэрээ харан үлдсэн Бэхи хүүгийн тухай баримтат нэвтрүүлэг оролцооны хэв загвараар хийгджээ.



Ажиглалтын хэв загвараар хийсэн нэвтрүүлгүүд уран бүтээлийн багийн оролцоог хязгаарлаж, гол дүр, үйл явдлыг өөрийн жам ёс, тогтсон маягаар байх боломжийг олгодог учраас энэ арга нь хамгийн идэвхтэйд тооцогддог.

Ялангуяа төрөл бүрийн жагсаал цуглаан, нийгмийн хурцадмал асуудлын талаар нэвтрүүлгүүдийг сэтгүүл зүйн үүднээс тэнцвэртэй хүргэхэд хамгийн тохиромжтой загвар

юм



(Гандөл, 2022) Сэтгүүлч Бэхи хүүтэй амьдралынх нь нөхцөл байдал, зан чанар, амжиргаатай холбоотой олон сэдвээр ярилцдаг. Ингэхдээ өөрөө гол дүр бус харин нэгдсэн цогц мэдээллийг Бэхи хүүгээс авч үзэгчдэд хүргэж буй дамжуулагч гүүр болж байна.

МҮОНТ-ийн “Эргэх дөрвөн цаг”, “Төл таван эрдэнэ” зэрэг нэвтрүүлгүүдийн зарим дугаар нь оролцооны аргаар хийгдсэн байдаг. Эдгээр нэвтрүүлэг нь сэдвийн хувьд тодорхой ч хэв маягийн хувьд зарим дугаарууд нь уламжлалт эх бичвэрт тулгуурласан тайлбарласан хэв маягтай, эсвэл сэтгүүлчийн оролцоонд тулгуурласан оролцооны хэв загвараар хийгдсэн байдаг.

Оролцооны хэв загварын давуу тал нь сэтгүүлч тухайн үйл явдлыг хөтөлж, асуултыг чиглүүлснээр үзэгч тодорхой мэдээлэл авах, хүргэх гэсэн мэдээлэл эмх цэгцтэй болдог. Тодорхой сэдвийг цаг хугацааны хүрээнд илэрхийлэх шаардлагатай нөхцөлд энэ загварыг түлхүү ашиглаж байна.

Сэтгүүлч-гүйцэтгэгч буюу сэтгүүлч төвтэй хэв загвар. Оролцооны загварт сэтгүүлч-оролцогчтой эн тэнцүү ярилцаж, түүнд асуулт тавьж байсан бол гүйцэтгэлийн хэв маягт сэтгүүлч гол дүр болдог. Өөрөөр хэлбэл, үйл явдал сэтгүүлчийг тойрон өрнөнө. Сэтгүүлч хөтлөгч-оролцогч-зарим талаар ажиглагчийн байр сууриар оролцдог. Энэ загвараар асуудал дэвшүүлсэн, шүүмжилсэн нэвтрүүлэг, сурвалжилгууд, эрэн сурвалжлах нэвтрүүлгүүд хийгддэг. Нэвтрүүлгийн үндсэн гол шугам сэтгүүлчийг даган өрнөдөг учраас тэнцвэрт байдлыг хангахгүй

бол хэт нэг талыг барьсан өрөөсгөл хандлага гарч ирж болзошгүй. Гэхдээ өөрийгөө бүрэн илэрхийлэх боломж бололцоогүй байгаа нийгмийн аль нэг бүлэг, хүмүүсийн эрх ашгийг хамгаалах тэдний дуу хоолойг хүргэхэд гүйцэтгэлт хэв загвар тохиромжтой хувилбар юм. Ийм бүлгийн өмнөөс ярих, тэдний амссан хор хохирол, бодит нөхцөл байдлыг сэтгүүлч бие даан эрэн сурвалжилж, тэр бүр гаргах боломжгүй баримтуудыг дэлгэнэ.

Интерактив хэв загварын тухайд 2000-аад оны үеэс мэдээллийн технологийн эрчимтэй хөгжлийн нөлөөгөөр шинэ хэлбэр болон гарч ирсэн. Баримтат нэвтрүүлгүүд уламжлалт дүрсэн өгүүлэмж, дуу чимээ, гэрэл зургийн бүтээлээс гадна инфографикууд, анимейш зэрэг график дизайны төрөл бүрийн аргыг ашиглах болсон байна. Телевизийн баримтат нэвтрүүлгийн интерактив хэв загварыг веб сайтын мультимедиа бүтээлтэй андуурдаг. Веб документайн аргыг ийм төрлийн нэвтрүүлэгт нийтлэг ашигладаг нь зарим тохиодолд андуурахад хүргэдэг байна.

Телевиз нь урлаг, технологи, бизнес зэрэг олон салбарын уулзвар дээр үйл ажиллагаа явуулдаг өвөрмөц онцлогтой. Гэхдээ тал бүрт салаалсан уулзварын цөм нь хэзээд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл байх болно. Энэ бол телевизийн мөн чанар юм. Тэгвэл телевизийн энэ мөн чанарыг илэрхийлэгч бүтээлийг тодорхойлъё гэвэл баримтат нэвтрүүлэг байх нь дамжиггүй билээ. Тийм ч учраас телевизийн бүтээлийг үндсэн болон дагавар гэж ангилан

баримтат нэвтрүүлгийг үндсэн гол төрөлд оруулдаг юм.

Тухайн нийгэм цаг үеийн түүхийг бичдэг баримтат нэвтрүүлгийн үнэ цэнийг нэмэгдүүлж, сонирхолтой, анхаарал татсан бүтээл хийхэд нөлөөлөх гол хүчин зүйл бол сүүлийн үеийн дээрх хэв загварууд юм. Үзэгчид хэн нэгнээр чиглүүлж, санаа бодлоо хашуулж, тулгуулах бус харин нийгэм, байгалийн жам ёсны оршихуйг хачир чимэггүй бодитоор нь хүлээн авч өөрсдөө дүгнэлт хийхийг нэгэнт хүсдэг болжээ. Энэ тохиолдолд баримтат нэвтрүүлэгт идэвхтэй ашиглаж буй дээрх аргууд үзэгчийн хэрэгцээ шаардлагыг хангахад уран бүтээлийн багийн ажлын чухал гүйцэтгэл болно. Тиймээс үзэгчид биднийг яагаад үзэхгүй байна, элдэв шоу, дуу хуур л сонгох юм гэж шууд дүгнэхээсээ өмнө тэдний сонирхлыг татах ямар арга, хэв загвар байгааг эрэлхийлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх нь уран бүтээлийн багийн ажлын үр дүнг сайжруулах нэг арга зам болно.

Эшлэл

1. Eastman S.T, Ferguson D.A. 2012. Media programming: strategies and practices., p 125-126
2. Хулан Б. 2019. Кино задлан уншихуй. УБ., х 251.
3. СУИС. Соёл урлагийн тайлбар толь. Телевиз VII. УБ., х 51.
4. Оюундарь Ц. 2016. Дүрвэгсдийн жимээр. 1-р анги. МҮОНТ. УБ.
5. Ариунболд Э. 2024. Төлчин хүүхэд. Хүннү Пикчерс. УБ.
6. Гандөл Б. 2022. Бэхи. Их өвийн эрэлд. УБ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Ариунболд Э. 2024. Төлчин хүүхэд. Хүннү Пикчерс. УБ.
2. Гандөл Б. 2022. Бэхи. Их өвийн эрэлд. УБ
3. Мэндхүү Г, Өнөрсайхан Т. 2014. Телевизийн тухай А-Я хүртэл. УБ.
4. Оюундарь Ц. 2016. Дүрвэгсдийн жимээр. 1-р анги. МҮОНТ. УБ.
5. Хулан Б. 2019. Кино задлан уншихуй. УБ., х 251.
6. СУИС. Соёл урлагийн тайлбар толь. Телевиз VII. УБ., х 51.
7. Шергова К.А. 2011. Докудрама-новый жанр. Мос.
8. Eastman S.T, Ferguson D.A. 2012. Media programming: strategies and practices. Cengage learning.
9. Eurodata TV worldwide. 2019. Global audience and content evolution. L.
10. James Roman 1998. Love, light and a Dream: Television past, present and future.
11. Hill A. 2005. Reality TV: Audiences and popular factual television. L.
12. Museum of Broadcast communications. 2013. Encyclopedia of television. NY.

Summary

This paper presents a case study of specific developments in the format on television. Factual program is a genre of nonfiction television programming that documents actual events and people. These types of programs are also described as observational documentary, reality show, reports, docudrama. Factual program is something that everyone watches and the most common forms of it are the news and investigative programs.

Keywords: documentary, document-tary film, observational style, explanatory style, performance style, participatory style, interactive style.